

ГАДААДАД СУРАЛЦАЖ БУЙ ОЮУТНУУДЫН СУРАЛЦАХ СЭДЛИЙН ТАЛААРХ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Ц. Энхнаран
Доктор (Ph. D.)

Техник, технологийн дээд сургууль

baznagaа2012@yahoo.com

Хураангуй: Манай улсын хөгжилд залуучуудыг чадварлаг шинийг эрэлхийлдэг, өөрийгөө дайчилдаг боловсон хүчин болгохын тулд оюутан ахуй цагаас нь сурах сэдэл, хэрэгцээг судалж, амжилт гаргах идэвхи сэдлийг бий болгох нь чухал. Ямар нэгэн зүйлийг сэтгэлээсээ чанартай хийж гүйцэтгэнэ гэдэг бол хүний тухайн зүйлдээ хандаж байгаа хандлага сэдэлтэй холбоотой. Иймээс энэхүү судалгааны ажилдаа оюутнуудын амжилтын хэрэгцээ болон бүтэлгүйтэлээс зайлсхийх сэдэл, эрсдэлийн төвшинг тооцох, бэлэн байх асуудлуудыг түлхүү оруулж судалсан бөгөөд үүний үндсэн дээр сургалтандаа оюутнуудыг сэдэлжүүлэх тал дээр анхаарал хандуулахыг зорьлоо

Түлхүүр үгс: Оюутнуудын амжилтын хэрэгцээ, сурах сэдэл

УДИРТГАЛ

Зорилго: Оюутнуудын амжилтын хэрэгцээ болон бүтэлгүйдэл ба шийтгэлээс зайлсхийх төвшинг тодорхойлох

Зорилт: Сэдэвтэй холбогдох онолын ном зохиол, интернетийн сайтуудуудас уншиж судлах гадаадад суралцаж буй оюутнуудын амжилтын хэрэгцээний төвшинг тодорхойлох
Асуулгын аргаар өөртөө итгэх болон эрсдэлийн төвшинг тодорхойлох

Аргазүй :

-Бие хүний амжилтын хэрэгцээний төвшинг тодорхойлох
Т.Элирсийн арга зүй

-Хувь хүний бүтэлгүйтэл шийтгэлээс зайлсхийх хамгаалалын сэдэл Т.Элирсийн арга зүй

-Асуулгын арга

-Ажиглалтын арга

Судалгааны хамрах хүрээ :

Өвөр Монголын Багшийн Их Сургуульд суралцаж байгаа монгол оюутнууд

Өнөө цагийн багш бид улсын хөгжлийг чиглүүлэн тодорхойлогч боловсон хүчнийг төрүүлэн бэлтгэдэг үйлдвэрлэлийн эзэд билээ. Тиймээс сурагчдыг чадварлаг, өөрийгөө дайчилдаг иргэн болгохын тулд сурагч цагаас нь тэдний сурах сэдэл, сонирхол, хэрэгцээг судлаж, амжилт гаргах идэвхи сэдлийг бий болгох нь чухал болоод байгаа билээ. Сонирхол нь хүний амьдралын нийгэм- түүхийн нөхцөл болон тухайн тодорхой нөхцлөөс шалтгаалдаг байна. Иймд суралцагчдын танин мэдэх үйл ажиллагааг зөв зохион

байгуулахад сонирхол чухал ач холбогдолтой.

Хүний сонирхол хэрэгцээ, хүсэл тэмүүлэл, сэтгэл хөдлөл зэрэг нь сэдлийн үүргийг гүйцэтгэж өгдөг. Ямар нэгэн зүйлийг сэтгэлээсээ чанартай хийж гүйцэтгэнэ гэдэг нь хүний тухайн зүйлдээ хандаж байгаа хандлага сэдэл, сонирхолтой холбоотой юм.

СУРАЛЦАХ СЭДЭЛ СОНИРХЛЫН ТУХАЙ ОНОЛЫН ТОЙМ

Монгол улсын нийгмийн бүх салбарт гарч буй өөрчлөлт шинэчлэл, хүн төрөлхтний ойрын ирээдүйн иргэдийн боловсролын хэрэгцээ, боловсролын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсруулан “Монгол улсын төрийн бодлогын үндэс”-д Монгол улсад боловсрол нь иргэн бүрийг бүх талаар хөгжүүлэх, Монгол улсын шинжлэх ухаан, технологийн дэвшил, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгах, баялаг бүтээх чухал эх сурвалж, үндэсний тусгаар тогтнол аюулгүй байдлыг баталгаа болгохыг иш үндэс болгон төрөөс боловсролыг нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ гэж заасан байна.

Боловсрол нь хүн төрөлхтний амьдрах ухаан, соёлыг үеэс үед дамжуулж байгаа нийгмийн үзэгдэл гэж хамгийн ерөнхий утгаар тодорхойлж болно.

Боловсролын хөгжилд нэмэр хандив, тус дөхөм болохуйц сургалтын технологийг өөрчилж

шинэчлэн түүнийг улам бүр боловсронгуй болгодог боловч соёлын шинэ үнэлэмж, үнэт зүйлсийг шинээр хүлээн авахын хэрээр сургалтын технологийн шинэчлэл хийх зайлшгүй хэрэгцээ нийгмийн амьдрал хөгжлийн шаардлагаас урган гарч байна.

Сургалтын арга зүйн шинэчлэл нь агуулгын гол зорилго болох суралцагчдыг тодорхой түвшний мэдлэг эзэмших арга барилд сургах бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, тэднийг амьдрах ухаанд сургахад чиглэгдсэн байвал зохино. Түүнчлэн сургалтын тогтолцоо болон технологийн шинэчлэлийн гол стратегийн нэг нь сургалтын арга зүй, хичээлийн заах аргын шинэчлэл, түүнийг байнга боловсронгуй болгох асуудал юм. Сургалт нь сургууль, хичээлийн түвшинд “суралцах – сургах” үйл ажиллагааны нэгдэл гэдэг утгаараа илүү тод илэрдэг.

Нийгмийн шинэ хуучин тогтолцоо дахь боловсролын шинэ хуучин зорилгыг харьцуулан үзвэл юуны өмнө хэний хэрэгцээг түлхүү анхаарч, энэ хэрэгцээтэй уялдаад хэний үйл ажиллагаа голлодог, улмаар ямар хандлага бий болсон нь тодорхой байна.

Бие хүний үйл ажиллагааны сэдэл, сэдлийн төлөвшил

Хүний зан үйл өдөөж түлхэц өгөх, зохицуулах гэсэн хоёр үндсэн чиг үүргийг гүйцэтгэж байдаг. Сэтгэлийн хөдөлгөөн, мэдрэмж зан төлөв, авьяас билэг, танин мэдэхүй зэрэг нь зохицуулах

хэсэгт хамаарна. Зан үйлийн өдөөх чиг үүрэг нь хүний үйл ажиллагааны эрчим хүчний хангамж, чиглэл, дахин давтагдах байдлыг тодорхойлно. Харин зохицуулах чиг үүрэг нь хүний үйл ажиллагааны эхлэх, үргэлжлэх, төгсгөлд нь ямар үр дүнд хүрсэн байхыг нөхцөл байдалтай уялдуулан зохицуулж байдаг. Хүний зан үйл, үйл ажиллагааны өдөөх, түлхэц өгөх механизмыг ойлгохын тулд **сэдэл /мотиваци/, сэдлэгүүд /мотив/** гэсэн нэр томёонуудыг сайтар ойлгох хэрэгтэй болно. Эдгээр ойлголтууд нь ямар нэг байдлаар сонирхол, зорилго, эрмэлзэл, тэмүүлэл, өдөөлт зэргийн талаарх төсөөллийг өөртөө багтаахын хамт гадаад орчны нөлөөллийн дор хүн зохих ёсоор биеэ авч явах байдал мөн энд хамаарна. Мөн хүний үйл ажиллагааны зохицуулалт. Үйл явц, үр дүнг дээшлүүлэхэд нөлөөлдөг элдэв шалтгаан хүчин зүйлүүд эдгээр ойлголтонд багтана. Хүний зан үйлийн өдөөх, идэвхжүүлэх талыг тодорхойлоход ашигладаг сэтгэл судлалын бүхий л ойлголтуудын дотор хамгийн ерөнхий утгатай нь сэдэл, сэдлэгүүд гэсэн ойлголтууд байдаг. [1]

Хэрэгцээ сэдлийн талаарх орчин үеийн онол, үзэл баримтлал Сэдэл болон хэрэгцээний тухай янз бүрийн онол, үзэл баримтлалууд бүр эртний Грекийн гүн ухаантнуудын бүтээлд тусгалаа олсон байдаг. Гэтэл өнө үед ийм

онол маш олон тоотой болжээ. Орчин үеийн мотивацийн олон хандлагуудыг ерөнхийд нь:

-Агуулгын

-Процессийн гэж 2 ангилдаг.

Агуулгын онол нь: хүний дотоод хэрэгцээнд тулгуурласан мотивацийг тайлбарладаг. Гол төлөөлөгч нь Абрахам Маслоу, Дэвид Макклеланд, Фрэдрик Герцберг нар юм.

Мотивацийн агуулгын онолуудад хүний хэрэгцээг ерөнхийд нь 2 ангилдаг:

1. Анхдагч хэрэгцээ. Физиологийн хэрэгцээ /өмсөх, идэх, уух, унтах, амрах, амьсгалах г.м/

2. Хоёрдогч хэрэгцээ: өөрийн мөн чанараараа хүний оюун санаа, сэтгэлзүйн хэрэгцээг хэлнэ. Жишээ нь: үйл ажиллагаандаа амжилт гаргах эрмэлзлэл, хүндлүүлэх, хамт олондоо хамааралтай байх, эрх мэдэлтэй байх. Анхдагч хэрэгцээ хүн бүрт ижил байдаг бол хоёрдогч хэрэгцээ боловсрол, оюун санааны хөгжил, амьдралын хуримтлуулсан туршлагаас хамаарч харилцан адилгүй байна. [2]


ОЮУТНУУДЫН СУРАЛЦАХ СЭДЛИЙГ СУДАЛСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Амжилтын хэрэгцээ

-Өвөр Монголын Багшийн Их Сургуульд суралцаж байгаа монгол 66 оюутан оролцсон бөгөөд

45% нь эрэгтэй, 55% нь эмэгтэй оюутнууд байсан. График-1 харуулсанаар маш өндөр амжилтын хэрэгцээ нь А3 ангийн хувьд арай илүү, харин А1 ангийн хувьд доогуур гарч байгаа нь хэлний мэдлэгийн түвшин өндөр ангийн оюутнууд арай илүү амжилтын хэрэгцээтэй байж болох талтай юм. Харин А3 ангийн хувьд өндөр буюу дунд амжилтын хэрэгцээ нь яг ижилхэн 37% тай гарсан байхад нөгөө 2 ангийн хувьд өндөр амжилтын хэрэгцээ нь давамгайлсан байна.


График-1



Маш өндөр амжилтын хэрэгцээтэй гарсан анги тус бүрийн оюутнуудын хүйсийн харьцааг харуулбал:

-анги тус бүрт 2, 2 маш өндөр амжилтын хэрэгцээтэй оюутнууд байгаа нь ангид манлайлагч оюутнууд байж хоорондоо өрсөлдөж сурдаг талтай байж болох юм.


График-2



Өндөр амжилтын хэрэгцээтэй гарсан оюутнуудыг хүйсээр нь харуулбал:

-График-3 аас харахад А2 ангийн эрэгтэй оюутнууд нь ерөнхийдөө ижилхэн жигд амжилтын хэрэгцээтэй харин эмэгтэйчүүдийн маш бага хувь нь өндөр амжилтын хэрэгцээтэй гэж гарсан нь харагдаж байна. А3 ангийн хувьд эрэгтэйчүүдийн 70% нь өндөр байгаа нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээсээ илүү сурах, амжилт гаргах мотиваци өндөртэй нь харагдаж байна.


График-3



Судалгаанд оролцсон бүх оюутнуудын амжилтын хэрэгцээ

-Судалгаанд оролцогчдын 48% нь өндөр амжилтын хэрэгцээтэй, 34% нь дунд амжилтын хэрэгцээтэй, 18% нь маш өндөр гэж гарсан байгаа нь харагдаж байна. Иймээс дунд мотивацитай байгаа оюутнуудыг өндөр мотивацитай болгох талаар багш нар нь анхаарч оюутнуудыгаа сэдэлжүүлэн, тэд өөрсдөө ч хичээх хэрэгтэй юм.


График-4



Дунд амжилтын хэрэгцээтэй гарсан оюутнуудыг хүйсээр нь харуулбал

-График-5 аас харахад А1 ангийн эмэгтэйчүүд ихэнхи нь дунд, харин 20% эрэгтэй нь дунд амжилтын хэрэгцээтэй гэж гарсан байна. Харин А3 ангийн хувьд дунд мотивацитай гарсан эрэгтэй байхгүй, дандаа эмэгтэйчүүд байгаа нь харагдаж байна. Энэ нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү өндөр IQ-тай байдагтай холбоотой байж болох юм.

График-5



-Хүмүүст бүтэлгүйтэл, золгүй явдал байх вий гэх айдас байх тусмаа хамгаалалын сэдэл өндөр байж амжилтанд хүргэх хөшүүрэг болдог гэж Мак. Клеманда дүгнэсэн байдаг. ӨМБИС-ийн оюутнуудын хувьд бүтэлгүйтэлээс хамгаалах сэдэл нь бага, өндөр, дунд зэрэг гэсэн нь адилхан үзүүлэлттэй гарсан байна. Энэ нь судалгаанд оролцогчдын

хувийн онцлогтой холбоотой гэж үзэж байна.

График-6



-Өөрийн үнэлэмж нь судалгаанд оролцсон оюутнуудын хувьд дунд гэсэн нь 50% байгаа нь харагдаж байна. Харин өөрийн үнэлэмж өндөртэй байгаа нь 30% байна, өөрийгөө үнэлдэггүй гэсэнд судалгаанд оролцогчдын 20% нь хариулт өгчээ. Өөрийн үнэлэмж өндөр байх тусам өөртөө итгэх итгэл нь өндөр байдаг.


График-7



Таны амжилтанд хүрэх гэсэн хэрэгцээ, хүсэл тэмүүлэл хэр зэрэг түвшинд байна вэ?

-Судалгаанд хамрагдсан оюутнуудын амжилтанд хүрэх гэсэн хэрэгцээ нь дундаж болон өндөр төвшинд байгаа нь уг графикаас харагдаж байна. энэ нь мөн сурч байгаа мэргэжилийн онцлогоос хамаарч болох талтай.

График-8



-Судалгаанд оролцсон оюутнуудын хувьд өөртөө маш их итгэдэг гэсэн нь 56%, дунд зэрэг итгэдэг нь 44% байна. Өөртөө итгэх итгэл өндөр байх тусам эрсдэлд тэр хэрээр бэлтгэлтэй байж бүтэлгүйтлээс хамгаалж чаддаг байна. Эндээс харахад өөртөө итгэдэггүй хүн огт байхгүй байгаа нь сайшаалтай юм.

График-9





График-10 ын хувьд ямар нэгэн зүйл хийхдээ тохиолдож болох эрсдэлийг ямар ч байсан тооцож үздэг нь харагдаж байна. Эрсдэлийг урьдаас тооцох нь амжилт гаргах гол хөшүүрэг болдог байна.

График-10



-Дээрхи графикийн хувьд зорилгодоо хүрэхийн тулд ямар ч бэрхшээлийг даван туулж чадна гэсэн нь 76%, мэдэхгүй байгаа нь 24%, бэрхшээлийг даван туулж огт чадахгүй гэсэн хүн байхгүй байгаа нь сайн талтай байна. Судалгаанд оролцсон оюутнууд маань өөрийн гэсэн зорилготой, зорилгодоо хүрэхийн тулд тодорхой хэмжээний бэрхшээл байдаг гэдгийг ухамсарлан эрсдэлийг тооцон үзсэн байгаа нь сайшаалтай байна. Хүн зорилготой байх тусам эрсдэлд бэлтгэх байдал өндөр байдаг байна гэж дүгнэж байна.

График-11




График-12



График-13





График-14



ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Оюутнуудын амжилтын хэрэгцээг судалж, нөлөөлөх зарим нэгэн хүчин зүйлсийг хоорондоо уялдаа холбоотой болохыг илрүүлж дараах дүгнэлтэнд хүрлээ.

Өвөр Монголын Багшийн Их Сургуулийн судалгаанд оролцсон оюутнуудын хувьд амжилтын хэрэгцээ нь өндөр байгаа нь судалгааны үр дүнгээс ажиглагдлаа. Энэ нь өөр оронд суралцаж байгаа оюутнууд бусад сургуулийн оюутнуудаас илүү их хичээлтэй, мөн хичээл нь хүнд гадаад хэлнээс нарийн мэргэжилийн талаар мэдээлэл авдаг, өөрийн улс орны нэр хүндтэй холбоотой гэдэг утгаараа оюутнуудын сурах сэдэл өндөр амжилт гаргах гэсэн хэрэгцээ их байдаг байна. Энэ нь хичээл хүнд шалгалтаа ч хатуу чанга шүүн авдагтай холбоотой байж болох юм. Өвөр Монголын Багшийн Их Сургуульд суралцагчид хэл сурч чанартай боловсон хүчин болох гэсэн хэрэгцээ өндөр болж ирдэгтэй холбоотой.

-Амжилтын сэдэл өндөртэй оюутнууд нь /36,7%/ , өөртөө итгэх итгэл өндөр /56%/ , зорилгодоо хүчтэй тэмүүлдэг /76%/ , эрсдлийг тооцдоггүй. Эндээс үзэхэд амжилтын сэдэл өндөртэй оюутнууд зорилгодоо хүрэхийн тулд хүчтэй тэмүүлдэг.

-Амжилтын сэдэл дунд байгаа оюутнууд өөртөө итгэх итгэл /43%/ , өмнөө тавьсан зорилго /24%/ , эрсдэлийг тооцдог /66%/ . Эндээс үзэхэд эрсдэлийг хэтэрхий их тооцоноос зорилго бага тавьдаг.

-Амжилтын сэдэл доогуур оюутнууд /30%/ өөртөө итгэх итгэл /0%/ зорилго /0%/ эрсдэлийг тооцдоггүй /4%/ . Эндээс үзэхэд зорилгогүй учраас эрсдэлээс айдаггүй.

Маш өндөр амжилтын сэдэлтэй оюутнууд нь өөрийн гэсэн зорилготой, өөртөө итгэх итгэлтэй, зорилгодоо хүрэхэд тохиолдож болох эрсдэлийг тодорхой хэмжээгээр тооцсон, эрсдэлээс хамгаалах сэдэлтэй болсон байна. Энэ нь суралцаж буй орчинтой холбоотой. Гадаадад байгаа хүн эрсдэлийг байнга тооцож тодорхой хэмжээний хамгаалалтай, сэрэмжтэй байдаг.

Дунд амжилтын сэдэлтэй оюутнууд ч мөн адил өөрийн үнэлэмж, өөртөө итгэх итгэлтэй байдаг байна эдний хувьд өөрийн гэсэн зорилго тавиагүй бөгөөд зорилгогүй учраас дараа дараагийн эрсдэлийг тооцох чадвар, хамгаалалын сэдэл нь бага учир амжилт гаргах гэсэн хэрэгцээ дунд байдаг нь тогтоогдлоо. Дунд амжилтын сэдэлтэй оюутнууд нь ихэвчлэн бага курсын оюутнууд байгаа нь судалгааны үр дүнгээс харагдлаа

Бага амжилтын сэдэлтэй гарсан оюутнууд нь өөрийн үнэлэмж итгэл буураад эхлэх юм бол дараагийн хэрэгцээ гарч ирэхгүй сурах сэдэл нь буурдаг нь тогтоогдлоо. Хүний энгийн аль нэг хэрэгцээ хангагдаагүй тохиолдолд дараагийн хэрэгцээ бий болох боломжгүй байдаг гэсэн санаа А.Маслоугийн онолд тусгалаа олсон байдаг. Уг онолоор оюутнуудын өөртөө итгэх итгэл, өөрийгөө хүндэтгэн үзэх хэрэгцээ хангагдаагүй бол дараа дараагийн шатны өөрийн өмнөө тавьсан

зорилго, зорилгодоо хүрэх чадвар, зорилгод хүрэхэд тохиолдож болох эрсдэлийг тооцох чадвар, эрсдэлээс хамгаалах сэдэл зэрэг дээд хэрэгцээнүүдийг хангах боломжгүй болно.

Энэ бүхнээс дүгнэн үзэхэд миний дэвшүүлсэн сурах сэдэл нь амжилтын хэрэгцээтэй шууд холбоотой гэсэн санаа батлагдсан боловч амжилт гаргахад тодорхой үе шатыг дамждаг болох нь тогтоогдлоо. Иймээс багш сурган хүмүүжүүлэгч нар оюутнуудын өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх тал дээр анхааран өөрийн гэсэн зорилготой түүндээ хүрэх арга замаа тооцоолсон бие хүн болгон төлөвшүүлэхэд анхаарч, оюутнууд ч өөртөө итгэлтэй байж амьдралын зорилго хүсэл тэмүүлэлтэй байх нь чухал юм гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

1. Алла.С.,Орнштейн. Идэвхтэй сургалтын стратеги УБ.,2001 он
2. Батхуяг С.,Сурган хүмүүжүүлэх зүйн үндэс Ред. С Батхуяг УБ.,2000.
3. Дэлгэржав.М, Сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал УБ., 2012
4. Жадамба.Б. Чимэдлхам.Ц, Судалгааны арга зүй., 2001
5. Мягмар.О, Цэрэндондов.П. Эрдэнэчулуун.Д. Туяа.Б, Оюунгэрэл.С нар Сэтгэл судлал УБ., 2005.
6. Мягмар О.,Харилцааны сэтгэл зүй УБ.,2003
7. Мягмар О., Хүүхдийн хөгжил УБ., 2003
8. Нэргүй С.,Сурлагаар хоцрогсодтой ажиллах тухай “Сурган хүмүүжүүлэгч” УБ.,1985.№4
9. https://en.m.wikipedia.org/psychology.Motivation_learned_Motivation.
10. John.Dworetzky Psychology New York, USA. 1988.page 290